



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



СПОРТЫН САЛБАРЫН ЗАРИМ АСУУДЛЫН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судлаач Б.Нямдаваа

2023.10.10



АГУУЛГА

1. Судалгааны ерөнхий мэдээлэл
2. Асуулт тус бүрийн дүгнэлт
3. Бүлэгчилсэн дүгнэлт
4. Дүгнэлт болон зөвлөмж



Судалгааны үндэслэл

- Спортын маргаан, зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх, допингийн эсрэг байгууллага хэрхэн ажиллаж буйг, мөн Спортын тухай хууль, дүрэм журам нь бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буй тухай юм. Үүнийг судалснаар Монгол улсад спортын салбарт төрөөс хэрхэн хяналт тавих, спортын байгууллагууд болон допингийн эсрэг байгууллагуудын үйл ажиллагаа ямар түвшинд байгааг хөндлөнгөөс харах зорилготой болно.
- Судалгааны асуулга бэлдэхдээ Биеийн тамир, спортын тухай хуулийг судлан бэлдсэн.
- Мэдээллийн нэгэн сайтад Үндэсний Допингийн эсрэг байгууллага хэрхэн ажиллаж буйг мэдээлсэн бөгөөд мөн холбогдох байгууллагууд нь хяналт тавьж чадахгүй байна. Энэ мэтчилэн жишээнүүд дээр тулгуурлан асуулга бэлдсэн.



Онолын ач холбогдол

- Спортын байгууллагуудын үйл ажиллагааны мэдээлэл болон хуулийн хэрэгжилтийг харж болно.
- Дараа дараагийн судалгааны суурь судалгаа болно.

Практик ач холбогдол

- Спортын салбарын хууль дүрэмд нэмэлт, өөрчлөлт орох түүнд тавигдах хяналт сайжирна. Хяналт сайжирснаар спортын салбарт маргаан зөрчилдөөн бага гарна. Мөн маргаан гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар байгууллагууд анхаарч ажиллана. Допингийн эсрэг байгууллага шинэчлэгдэж тамирчид, багш, гишүүддээ мэдээ мэдээллээр хангах зарчим нь сайжирна.

Нийгмийн ач холбогдол

- Иргэдийн спортын байгууллага, тамирчидад итгэх итгэл нэмэгдэнэ. Үндэсний допингийн эсрэг байгууллагын ажил шинэчлэгдэн сайжирснаар иргэдийн допингийн байгууллагад хандах хандлага өөрчлөгдөнө. Спортын салбарын цаашид хөгжих гүүр нь болно.



Судалгааны ерөнхий мэдээлэл

- Судалгааны зорилго, зорилт
- Судалгааны хамрах хүрээ
- Судалгааны арга зүй





Судалгааны зорилго, зорилт

Зорилго

Спорт болон допингийн эсрэг дүрэм, журмаас үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэж байгаа, хууль тогтоомжийн хувьд хангалттай зохицуулагдаж байгаа эсэхийг судлах.

Зорилт

- ❖ Спортын арбитрын тухай асуулга бэлдэх
- ❖ Спортын болон допингийн эсрэг дүрмийг судлан асуулга бэлдэх
- ❖ Үндэсний их баяр наадмын тухай судлан асуулга бэлдэх
- ❖ Биеийн тамирын тухай судлан асуулга бэлдэх
- ❖ Асуултуудаа нэгтгээд судалгаанд оролцох субъектүүдээсээ авах



СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд оролцогчдын тоо

- ❖ Гишүүн-0
- ❖ Ажилтан -10
- ❖ Шүүгч-12
- ❖ Багш-12
- ❖ Дасгалжуулагч-23
- ❖ Тамирчин-243



N=300

Судалгаа явагдах хугацаа 2023.08.31-
2023.09.13



Судалгаанд хамрагдсан газар

- ❖ Биеийн тамир спортын хороо
- ❖ Үндэсний спортын төв
- ❖ Үндэсний олимпын хороо
- ❖ Дүүргүүдийн спортын хороо
- ❖ Спортын клубууд (нэрээ өгөхөөс татгалзсан)





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



СУДАЛГААНД АШИГЛАСАН ПРОГРАММ ХАНГАМЖ

Тайлан боловсруулах



Microsoft 365

Үг үсгийн алдаа шалгагч


BlogMN.Net

Манай судалгаа нь түүврийн аргаар оролцогчдоо хамруулан, хаалттай анкетын аргаар боловсруулан авсан.



Асуулт 1

Та спортын салбарт ямар хамааралтай вэ?




Манай судалгаанд оролцогчдын 81% нь буюу дийлэнх хувийг **тамирчид** эзэлж байна.

Гишүүн	0%
Ажилтан	3%
Шүүгч	4%
Багш	4%
Дасгалжуулагч	8%
Тамирчин	81%



Асуулт 2

Таны бодлоор спортын байгууллагууд нь шүүгч, тамирчид, багш, дасгалжуулагч, гишүүдээ ямар хэмжээнд дэмждэг вэ?




Судалгаанд оролцогчдын 68.6% нь спортын байгууллагын дэмжлэг дунд гэж үзсэн.

Муу	0.3%
Хангалтгүй	12.3%
Маш сайн	18.6%
Дунд	68.6%



Асуулт 3

Шүүгч, дасгалжуулагч, тамирчин, багш, ажилтан
ёс зүйн ямар түвшинд байна гэж та үзэж байна вэ?




Шүүгч, дасгалжуулагч,
тамирчин, багш,
ажилтны ёс зүйн
түвшнийг 58% нь
дунд гэж үзсэн байна.

Муу	1%
Маш сайн	18.6%
Хангалтгүй	22.3%
Дунд	58%



Асуулт 4

Та спортод үүсч байгаа маргаан
зөрчилдөөнийг юу гэж бодож байна вэ?




Спортод үүсч байгаа
маргаан зөрчилдөөн
шударга бус үзэгдэл гэж
28,3% үзсэн байна.

Хэвийн	22.3%
Байж боломгүй	22.6%
Байж л байдаг	26.6%
Шударга бус	28.3%



Асуулт 5

Та спортын ертөнцөд гарч байгаа маргааныг хэрхэн шийдэж байна гэж үзэж байна вэ?




Судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 4 нь хангалтгүй шийддэг гэж үзсэн.

Мэдэхгүй байна	11.3%
Муу	14.3%
Шударга шийдэж байна	33%
Хангалтгүй	41.3%



Асуулт 6

Танай байгууллагад шүүгч, багш, дасгалжуулагч, тамирчидтай холбоотой Ёс зүйн зөрчил маргаан гардаг уу?




Спортын байгууллагуудад ёс зүйн зөрчил заримдаа гардаг гэж 61% нь хариулсан.

Мэдэхгүй	10.4%
Тийм	12.6%
Үгүй	16%
Заримдаа	61%



Асуулт 7

Танай байгууллагад шүүгч, багш, дасгалжуулагч, тамирчин, гишүүдийн хооронд гардаг Ёс зүйн зөрчил, маргааныг шийдвэрлэх бүтэц, бүрэлдэхүүн байдаг уу?




10 хүн тутмын 4 нь маргаан шийдвэрлэх бүтэц байхгүй гэсэн бол 36% нь мэдэхгүй гэж хариулсан.

Байгаа	24.3%
Мэдэхгүй	34.6%
Байхгүй	41%



Асуулт 8

Гарсан маргаан, зөрчлийг хэрхэн
ямар байгууллагаар шийдүүлдэг вэ?




Судалгаанд оролцогчдын 46% нь байгууллагын удирдлагаар шийддэг гэсэн бол 20.3% нь сахилга, ёс зүйн хороогоор шийдүүлдэг гэжээ.

Хуулийн байгууллага	4.3%
Хяналтын зөвлөл	6%
Хоорондоо тохиролцдог	11.3%
Мэдэхгүй байна	13.6%
Сахилга ёс зүйн зөвлөл	20.3%
Байгууллагын удирдлага	44.6%



Асуулт 9

Танай байгууллага ёс зүйн болон хууль эрх зүйн сургалт семинар тогтмол явуулж мэдээллээр хэрхэн хангадаг вэ?




Судалгаанд оролцогчдын 17.3% тогтмол авдаг гэж хариулжээ.

Мэдэхгүй байна	6.3%
Үгүй	11.6%
Огт өгдөггүй	15.3%
Тийм	17.3%
Хангалтгүй	49.3%



Асуулт 10

Танай байгууллага допингийн эсрэг сургалт, семинар тогтмол явуулж мэдээллээр хангадаг уу?




Судалгаанд оролцогчдын
13.3% нь тогтмол авдаг
гэж хариулжээ.

Мэдэхгүй байна	7.3%
Тийм	13.3%
Үгүй	16.3%
Огт өгдөггүй	28.6%
Хангалтгүй	34.6%



Асуулт 11

Та допинг, спортод хамааралтай хууль, эрх зүйн мэдээллийг хаанаас авдаг вэ?




Судалгаанд оролцогч 10 хүн тутмын 4 нь мэдээллийг багш, дасгалжуулагчаасаа авдаг гэсэн бол 16% нь удирдлагаасаа гэж хариулжээ.

Спортын арбитр	8.6%
Legalinfo	11.3%
Найз нөхөд	12.6%
Бусад	15%
Байгууллагын удирдлага	16%
Багш дасгалжуулагч	36.6%



Асуулт 12

Танай байгууллагад допингтой холбоотой хэрэг маргаан гарч байсан эсэх, хэрэв тийм бол хэрхэн шийдвэрлэгддэг вэ?




Спортын салбараас нь шалтгаалан 25.3% нь **гарч байсан** гэсэн бол 16% нь **хэлэхийг хүсэхгүй байна** гэж хариулсан

Хэлэхийг хүсэхгүй байна	16%
Гарч байсан	25.3%
Гарч байгаагүй	26.3%
Санахгүй байна	32.3%



Асуулт 13

Спортын маргааныг шүүхээр биш спортын арбитраар шийдүүлэхийг та юу гэж боддог вэ?




10 хүн тутмын 4 нь **спортын арбитраар** шийдүүлэх нь зөв хэмээн үзсэн бол 16.6% нь шүүх салбарыг онцлогыг ойлгохгүй гэж хариулжээ.

Шүүхээр шийдэх нь буруу	3%
Шүүхээр шийдэх нь зөв	10.3%
Шүүх шударга шийдэж чадахгүй	13%
Шүүх хэт урт хугацаа шаарддаг	15%
Шүүх салбарын онцлогыг ойлгохгүй	16.6%
Спортын арбитраар шийдэх нь зөв	41.3%



Асуулт 14

Та Спортын арбитрын талаар ямар нэгэн мэдээлэл авч эсхүл сонсож байсан уу?




Спортын арбитрын мэдээллийг 36.6% нь ажлын хэлбэрээр л **сонсож** байсан хэмээн хариулсан.

Санахгүй байна	13.6%
Тийм	24%
Үгүй	25.6%
Сонсож байсан	36.6%



Асуулт 15

Спортын арбитрын шийдвэрлэж байсан хэргийн талаар сонсож байсан уу?




Спортын арбитрийн шийдсэн хэргийн талаар 22.3% **сонсож** байсан гэж хариулжээ.

Тийм	22.3%
Санахгүй байна	28.3%
Үгүй	49.3%



Асуулт 16

Сонсож байсан спортын арбитрын шийдвэрлэсэн шийдвэрийн талаар таны байр суурь ямар байдаг вэ?




Судалгаанд оролцогчдын 17% нь спортын арбитрын шийдвэрлэлтийг **сайн** хэмээн үзжээ.

Тийм	17%
Үгүй	39%
Санахгүй байна	44%



Асуулт 17

Танай байгууллагад Спортын арбитрын талаар гэрээ, хэлцэл болон дүрэм, журмын заалт бий юу?




Спортын арбитрын талаар гэрээ, хэлцэл болон дүрэм журмын заалт **байгаа** гэж 12.6% нь хариулсан байна.

Тийм	12.6%
Мэдэхгүй байна	18%
Санахгүй байна	32.3%
Үгүй	39.3%



Асуулт 18

Та спортын ямар нэгэн маргаан гарвал
хаана хандах вэ?




Спортын арбитрт 41.3% нь хандана гэсэн бол 40.6% нь байгууллагын удирдлагад ханддаг хэмээн хариулсан.

Мэдэхгүй байна	7.6%
Шүүх	10.3%
Байгууллагын удирдлага	40.6%
Спортын арбитр	41.3%



Асуулт 19

Та спортын арбитрын допингийн давж заалдах комисс нь допингийн хэрэг маргааныг шийдвэрлэдэг болсныг мэдсэн үү?




Судалгаанд оролцогчид 10 хүн тутмын 3 нь давж заалдах комиссын мэддээллийг мэдэхгүй бол 10 хүн тутмын 1 нь мэдэж байна.

Тийм	12.6%
Үгүй	27.3%
Санахгүй байна	60%



Асуулт 20

Та Монголын Үндэсний Допингийн Эсрэг Байгууллагыг ямар хэмжээнд ажиллаж байгаа гэж бодож байна вэ?




10 хүн тутмын 5 нь муу ажилладаг хэмээн үзэж байна.

Сайн	4.3%
Огт мэдэхгүй	21.6%
Дунд	25%
Муу	49%



Асуулт 21

Та Монголын Үндэсний Допингийн Эсрэг Байгууллагаас допингийн эсрэг сургалт, зөвлөгөө, мэдээлэл авч байсан уу?




Допингийн эсрэг сургалт, зөвлөгөө, мэдээллийг **59.3%** нь **хангалтгүй** гэж хариулсан бол **7.3%** нь мэдээлэл **авдаг** гэж хариулсан.

Тийм	7.3%
Үгүй	13.6%
Санахгүй байна	19.6%
Хангалтгүй	59.3%



Асуулт 22

Таны бодлоор Монголын Үндэсний Допингийн Эсрэг
Байгууллагын талаарх таны өгөх үнэлгээ?




46% нь **шинэчлэх шаардлагатай** гэж хариулсан.

Сайн	3.6%
Мэдэхгүй байна	4.6%
Дунд	21.6%
Муу	24%
Шинэчлэх шаардлагатай	46%



Асуулт 23

Та Монгол Улсын Засгийн газраас 2022 онд баталсан
Допингийн эсрэг үндэсний дүрмийн талаар мэдэх үү?




Судалгаанд
оролцогчдын 8.3%
нь **МЭДНЭ** гэж
хариулжээ.

Тийм	8.3%
Үгүй	17.6%
Санахгүй байна	18%
Сонсож байсан	56%



Асуулт 24

Таны бодлоор допингийн эсрэг хууль тогтоомж манай улсад ямар хэмжээнд хэрэгжиж байна гэж бодож байна вэ?




Оролцогчдын 52.3% нь допингийн эсрэг хууль тогтоомж **муу** хэрэгждэг гэж үзсэн байна.

Сайн	2.6%
Дунд	21.3%
Мэдэхгүй байна	23.6%
Муу	52.3%



Асуулт 25

Та Биеийн тамир, спортын тухай хуулийн талаар хэр мэдэх вэ?




10 хүн тутмын 5 нь спортын хуулийн талаарх мэдлэг дунд зэрэг байна.

Огт мэдэхгүй	9.3%
Сайн мэднэ	12.6%
Бага мэднэ	33.3%
Дунд мэднэ	44.6%



Асуулт 26

Та Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааг өөрийн бодлоор дүгнэнэ үү?




Судалгаанд оролцогчдын 50.6% нь дунд гэж хариулсан.

Сайн	2.6%
Мэдэхгүй байна	7.6%
Муу	14.3%
Хангалттай	24.6%
Дунд	50.6%



Асуулт 27

Та Монголын Үндэсний Олимпын Хорооны үйл ажиллагааны талаар сэтгэгдэл ямар байдаг вэ?




Оролцогчдын 56.3% нь дунд гэж хариулсан.

Сайн	3%
Мэдэхгүй байна	6.3%
Муу	9%
Хангалттай	25.3%
Дунд	56.3%



Асуулт 28

Үндэсний их баяр наадамд барилдсан бөхчүүдээс допинг илэрч байгааг та юу гэж бодож байна вэ?




10 хүн тутмын 7 нь допингийн талаар мэдээлэл муу учраас допингийн хэрэг их байна хэмээн үзсэн байна.

Бөхчүүдээс допингийн шинжэллгээ авах нь буруу	2%
Допинг хэрэглэх нь зөв	6.6%
Допинг хэрэглэж байгаа нь буруу	25.6%
Допингийн талаар урьдчилсан сэргийлэх сургалт, суртчилгаа мэдээлэл хангалтгүй учраас мэдэхгүй хэрэглэж байгаа байх	65.6%



Асуулт 29

Ёс зүйн зөрчлөөр Бөхчүүдийн барилдах эрхийг хасч байгааг та юу гэж бодож байна вэ?




Хасах нь **зөв** гэж 28.3% нь хариулсан бол **шийтгэлийг хүндрүүлэх** хэрэгтэй гэж 26.6% нь үзэж байна.

Сайн мэдэхгүй байна	8.3%
Буруу	14.6%
Эрхийг хасахгүйгээр өөр шийтгэл оноодог байх	22%
Шийтгэлийг өшөө хүндрүүлэх хэрэгтэй	26.6%
Зөв	28.3%



Асуулт 30

Хурдан морины уралдаанд сэрвээний өндөр тогтоож,
хэтэрвэл хасч байгааг та юу гэж бодож байна вэ?



Оролцогчдын 37.6% нь **буруу** хэмээн хариулсан бол 23% нь сэрвээний өндрийг **шинэчлэх** шаардлагатай гэж үзсэн байна.

Сайн мэдэхгүй байна	14%
Сэрвээний өндрийн хэмжээг дахин өөрчилж, шинэчлэх шаардлагатай.	23%
Зөв. Ийм зохицуулалт хэрэгтэй.	25.3%
Буруу. Монгол адуу ч гэсэн өндөр байж болно.	37.6%



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Гурав. Бүлэгчилсэн дүгнэлт



- ❖ Оролцогчдын дийлэнх олонх нь Тамирчид хамрагдсан.
- ❖ Судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 7 нь спортын байгууллагын дэмжлэг дунд мөн багш, тамирчид, дасгалжуулагч, шүүгчдийн ёс зүйн түвшин дунд хэмээн хариулсан нь спортын байгууллагын бодлогын бодит дэмжлэг болон ёс зүйн хандлага, төлөвшил, хүмүүжлийн үе шаттай, цогц бодлого дутагдаж байгааг харуулж байна.
- ❖ Спортын байгууллагад маргаан гардаг ч үүнийг шийдвэрлэх бүтэц байхгүй (Ёс зүйн эсхүл Сахилгын хороо) байгаа засаглалын хувьд төлөвшөөгүй, байнгын бус ажиллагаатай, оролцогчид (тамирчин, багш, дасгалжуулагч, ажилтан)-ны эрхийг хамгаалах хүсэл тэмүүлэл сул байна гэж судалдаанд оролцогчдын 10 хүн тутмын 4-5 нь үзжээ.
- ❖ Мөн гарсан маргааныг ихэнхдээ байгууллагын удирдлага шийдвэрлэдэг байна. Энэ нь оролцогчдын суурь эрхийг хамгаалах, тэгш боломж олгох, шударгаар шийдвэрлүүлэх боломжийг олгосон гэж үзэхэд хүндэрэлтэй байгааг харуулж байна.
- ❖ Хууль эрх зүйн болон Допингийн эсрэг сургалт семинар мэдээлэл хангалтгүй явагддаг ба үүнтэй холбоотой мэдээллийг багш, дасгалжуулагчдаас авдаг хэмээн 10 хүн тутмын 4-5 нь ийнхүү үзэж байна.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР



- ❖ Спорттой холбоотой хэрэг, маргааныг спортын арбитраар шийдвэрлэх нь зөв гэж ихэнхи нь үзсэн бөгөөд мэдээ, мэдээлэл муу байгааг судалгаанд оролцогчидийн хариулсанаас дүгнэхээр байна.
- ❖ Монголын Үндэсний Допингийн Эсрэг Байгууллага хангалтгүй ажилладаг, шинэчлэх шаардлагатай бөгөөд допингийн эсрэг дүрэм, журам муу хэрэгждэг гэж оролцогчдын 10 хүн тутмын 6 хүн нь ингэж үзсэн байна.
- ❖ Судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 5 нь спортын тухай хуулийг дунд зэрэг мэддэг.
- ❖ БТСУХороо болон Монголын Үндэсний Олимпын Хорооны үйл ажиллагааг дунд гэж оролцогчдын 100%-н 53% нь ийнхүү үзсэн байна.
- ❖ Үндэсний их баяр наадамд оролцдог бөхчүүдийн допингийн зөрчил болон ёс зүйтэй холбоотой хэрэг маргааны шийтгэлийг хүндрүүлэх хэрэгтэй бас үүнтэй холбоотой сургалт семинар муу байгаа учраас ийм зөрчлүүд их гарч байна хэмээн оролцогчид дүгнэсэн.
- ❖ Хурдан морины сэрвээний өндрийг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж оролцогчдын ихэнхи нь хариулсан.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



4. Дүгнэлт болон Зөвлөмж



- ❖ Энэхүү судалгааны зорилго бол спорттой холбоотой хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэдэг тухай болон спорттой холбоотой байгууллагуудын ажлыг тамирчид хэрхэн дүгнэх байсан.
- ❖ Судалгааны дүгнэлт нь спорттой холбоотой хэрэг, маргааныг шийдвэрлэх бүтэц байхгүй мөн оролцогчдын хувьд эрхээ хамгаалах үйл явцыг мэдэхгүй, оролцохгүй байх тохиолдол 1/2 -ийг эзэлж байна.
- ❖ Допингийн эсрэг сургалт, семинар болон хууль эрх зүй мэдээллийг хангалтгүй өгдөгөөс маргаан, зөрчилдөөн гардаг. Мөн яаж шийдвэрлүүлэх тухай мэдээлэл муу байна. Үүнтэй холбоотой мэдээллийг багш, дасгалжуулагчдаас авдаг.
- ❖ Биеийн тамир, спортын тухай хууль, Допингийн эсрэг үндэсний дүрмийг баталсан ч хэрэгжилт хангалтгүй байгааг энэхүү судалгаанаас харж болно.
- ❖ Допингийн эсрэг үндэсний байгууллага маш хангалтгүй ажиллаж байна. Энэхүү байгууллагад Засгийн газраас тавих хяналт муу байна.
- ❖ Үндэсний баяр наадмын тухайд бөхчүүдийн допингийн хэрэг болон ёс зүйтэй холбоотой маргааныг шийдвэрлэх хуулийг чангатгах ёстой хэмээн дүгнэж байна.



СУДАЛГААНААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ

- ✓ Допингийн эсрэг сургалт, семинар, зөвлөгөөг тогтмол, үе шаттай өгөх;
- ✓ Допингийн эсрэг ном, товхимол, гарын авлагаар хангаж мэдээлэх;
- ✓ Спортын байгууллагуудын багш, дасгалжуулагч, тамирчин, шүүгч, ажилчдад хууль эрх зүйн болон ёс зүйн сургалт семинарыг тогтмол, үе шаттай явуулах;
- ✓ Спортын хууль тогтоомжийн хэрэгжилтэд үр дагаврын болон бусад төрлийн судалгааг хийж, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох;
- ✓ Спортын байгууллагуудад гишүүн, тамирчин, багш, дасгалжуулагчтай холбоотой маргааны шийдвэрлэх бүтэц байхгүй байгаа нь эрхээ хамгаалах үйл явцыг ойлгомжгүй тэдгээрийн оролцоог хумиж байгаа тул хууль тогтоомжын зохицуулалтыг улам боловсронгуй болгох;
- ✓ Үндэсний допингийн эсрэг байгууллагад төрөөс тавих хяналтын эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, ойлгомжтой болгох;
- ✓ Үндэсний допингийн эсрэг байгууллагыг засаглал, бүтцийн хувьд Дэлхийн допингийн эсрэг байгууллагын дүрэм болон Олон улсын стандартын дагуу зохион байгуулах;
- ✓ Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаас гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд үр дагаврын болон бусад төрлийн судалгааг тогтмол хийх, мэдээлэх;
- ✓ Үндэсний бөхийн тамирчдад ёс зүйн зөрчлөөр оногдуулж буй хариуцлагын төрөл, хэлбэрийг илүү оновчтой, үр дүнтэй болгох ажилд судалгаа, мэдээллээр хангаж, бодлогын дэмжлэг үзүүлэх;
- ✓ Хурдан морины уралдааны сэрвээний өндөрийн хэмжээг дахин тогтоох боломжтой эсэх талаарх мэргэжлийн байгууллагын судлагааг явуулах;